

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	2-3

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	2-3
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Ганзориг, Да.Цогтбаатар;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Булгантуяа;
Тасалсан: Б.Заяабал.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Дэд хорооны дарга Д.Батбаяр одоогоор Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Өргөдлийн, Хүний хөгжил, нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Хууль зүйн байнгын хороод тус тус хуралдаж, 118 зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан бөгөөд мөн багш, эмч нарын цалин, өндөр насны тэтгэвэр нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гарч, 2025.09.01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд ихээхэн өөрчлөлт орох тул төсвийн зарлагыг дахин нарийвчлан тооцоолох хүртэл Дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд санал, дүгнэлт гаргах боломжгүй тухай мэдэгдэж, уг асуудлыг хойшлуулав./17:55/

Хуралдаан 03 минут үргэлжилж, 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
17 цаг 52 минут.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Батбаяр: Дэд хорооны эрхэм гишүүдийн амрыг айлтгая. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 58,3 хувьтайгаар бүрдсэн байна.

Өнөөдрийн Дэд хорооны хурал дээр Загджавын Мэндсайхан гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн, Ринчиндоржийн Батболд гишүүн, Чинбатын Номин гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн болон Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ингээд нэгэнт ирц бүрдсэн учраас Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Энэ одоогийн байдлаар нийтдээ 6 Байнгын хороо хуралдсан байна. Тэгээд энэ Байнгын хороо нь Өргөдлийн байнгын хороон дээр 53 зарчмын зөрүүтэй санал, Байгаль орчны байнгын хороон дээр 11 зарчмын зарчмын зөрүүтэй санал, Хууль зүйн байнгын хорооны дээр 5 санал, Төрийн байгуулалт дээр 7, Хүний хөгжил дээр 42 санал, Аюулгүй байдал дээр санал ирээгүй юм байна. Ингээд нийтдээ 118 зарчмын зарчмын зөрүүтэй саналууд ирсэн байна.

Тэгээд яагаад энийг хэлж байна вэ гэвэл анх 2025 оны 9 сарын 1-нд Сангийн яамнаас өргөн баригдсан 2026 оны төсвийн төсөл маань үндсэндээ 180 хувь өөрчлөгдөж байна. Тэгээд багш, эмч нарын цалин болон өндөр настны тэтгэврийг нэмэх бодлогын хэмжээний шийдвэр гарсан. Зарлагын тал дээр бол ихээхэн хэмжээний өөрчлөлт гарахаар байна. Тэгэхээр одоо өргөн баригдсан энэ төсвийн төслөөр Зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд санал, дүгнэлт гаргах боломжгүй байна гэж харагдаж байна. Яагаад гэвэл маш их хэмжээний өөрчлөлт гарчихсан байгаа учраас.

Ингээд Засгийн газар болон Сангийн яам зарлагын хэсгийг дахин нарийвчлан тооцоолоод, Дэд хорооны гишүүдэд бүрэн мэдээлж танилцуулаад, мөн Төсвийн байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгээр бусад Байнгын хороод дээр ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцээд, ажлын хэсэг дээр нэгтгээд, ингээд бэлэн болсных нь дараа Дэд хорооны хурал хуралдах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд энэ удаагийн хурлыг хойшлуулж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА